



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 58

Жаргалант

Багуудын нэр, дугаарыг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумын зарим багуудын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаас багийн оноосон нэршлийг өөрчлөх, шинээр нэр өгөх талаар ирүүлсэн хүсэлтийг хэлэлцээд сумын нутаг дэвсгэр дэх Засаг захиргааны анхан шатны нэгж болох багуудын оноосон нэр, дугаарыг дор дурьдсанаар өөрчилж, шинэчлэн баталсугай. Үүнд:

№	Багуудын дугаар	Оноосон нэр /Нэршил/	Харьяалагдах газар /нутаг дэвсгэр/
1.	1 дүгээр баг	Цог-Өндөр	1 дүгээр багийн нутаг дэвсгэр
2.	2 дугаар баг	Эрчим	2 дугаар багийн нутаг дэвсгэр
3.	3 дугаар баг	Тариат-Бүгдгээн	3 дугаар багийн нутаг дэвсгэр
4.	4 дүгээр баг	Тээл	4 дүгээр багийн нутаг дэвсгэр
5.	5 дугаар баг	Жаргалант	5 дугаар багийн нутаг дэвсгэр /Сумын төв/

2. Багуудын шинэчлэн баталсан дугаар, оноосон нэршлийн дагуу Иргэний бүртгэлийн мэдээллийн сан, Хүн ам, өрхийн мэдээллийн сан түүнтэй холбогдох бусад мэдээллийн санд гарсан зөрүүг арилгах асуудлыг холбогдох газарт нь уламжлан шийдвэрлүүлэхийг сумын Засаг дарга /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилт үр дүнг тооцож, биелэлтийг гаргуулан 2020 оны 12 дугаар сарын 20-ны дотор ИТХ-д танилцуулахыг ЗДТГ-ын дарга /Г.Нямханд/-д биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Бямбадорж/-д даалгасугай.



ДАРГА

Г.БЯМБАСҮРЭН